



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/224/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2022 он	Ахлах аудитор: Утас: 7036-2442	Т.Болор Цахим хаяг: bolort@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8. Аудитын гол асуудал	18
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕГ	Татварын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Ц. ЛХАГВАДОРЖ ТАНАА

2022.02.23 № СЭА-2022/224-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,908,003.95	32,289,087.21
33	АВЛАГА	0	976,241.21
33500	Бусад авлага	0	976,241.21
33510	Байгууллагаас авах авлага	0	976,241.21
35	БАРАА МАТЕРИАЛ	28,908,003.95	31,312,846.00
35400	Хангамжийн материал	28,908,003.95	31,312,846.00
35410	Бичиг хэргийн материал	1,823,660.00	1,552,769.56
35420	Аж ахуйн материал	8,679,069.00	21,614,156.14
35440	Түлш, шатах тослох материал	0	840,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,405,274.95	7,305,920.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	325,976,512.18	299,522,465.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	325,976,512.18	299,522,465.92
39200	Биет хөрөнгө	313,070,512.18	286,616,465.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	22,156,836.17	22,156,836.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,960,843.09	-5,938,555.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	160,800,000.00	160,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,682,528.12	-76,548,633.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	273,081,695.51	312,697,455.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-87,725,742.62	-142,856,276.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,540,000.00	32,869,251.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,388,008.11	-18,412,929.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,710,000.00	30,710,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,460,897.56	-28,860,682.06
39300	Биет бус хөрөнгө	12,906,000.00	12,906,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,906,000.00	12,906,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	354,884,516.13	331,811,553.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	976,241.21
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	976,241.21
41300	Өглөг	0	976,241.21
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	976,241.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	354,884,516.13	330,835,311.92
51	Засгийн газрын хувь оролцоо	354,884,516.13	330,835,311.92
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	369,861,425.84	369,861,425.84
51200	Хуримтлагдсан үр дүн	-14,976,909.71	-39,026,113.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-177,513,488.63	-14,976,909.71
51220	Тайлант үеийн үр дүн	162,536,578.92	-24,049,204.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	354,884,516.13	331,811,553.13

/төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,312,007,737.57	1,095,703,803.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	286,983,537.57	55,467,703.28
120	Нийтлэг татварын бус орлого	286,983,537.57	55,467,703.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	286,983,537.57	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.00	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	286,938,537.57	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	36,485,493.28
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	18,982,210.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025,024,200.00	1,040,236,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,025,024,200.00	1,035,236,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,025,024,200.00	1,035,236,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	5,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,067,202,925.86	1,094,565,217.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,067,202,925.86	1,094,565,217.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	976,159,130.67	1,048,610,921.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,352,963.63	705,709,166.41
210101	Үндсэн цалин	479,473,370.76	439,797,722.05
210102	Нэмэгдэл	108,766,042.48	125,803,446.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,878,010.00	70,894,174.36
210104	Урамшуулал	52,235,540.39	69,213,823.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,910,949.18	93,066,633.03
210201	Тэтгэврийн даатгал	58,231,144.66	64,859,134.95
210202	Тэтгэмжийн даатгал	7,417,138.59	7,205,971.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,470,025.31	5,653,896.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,785.04	1,395,239.31
210205	Эрүүл мэндийн даатгал	13,447,855.58	13,952,390.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,358,000.00	44,376,301.00
210301	Гэрэл, цахилгаан	2,140,000.00	197,267.00
210302	Түлш, халаалт	0	6,766,086.00
210303	Цэвэр, бохир ус	0	112,948.00
210304	Байрны түрээс	51,218,000.00	37,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,883,681.50	31,205,003.41
210401	Бичиг хэрэг	4,045,100.00	6,533,263.57
210402	Тээвэр, шатахуун	5,133,000.00	5,332,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,017,000.00	8,612,440.00
210404	Ном, хэвлэл	207,600.00	140,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	684,700.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,796,281.50	10,493,499.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,148,000.00	3,449,500.00
210604	Урсгал засвар	1,148,000.00	3,449,500.00

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	5,093,800.00	8,944,000.00
210702	Дотоод албан томилолт	5,093,800.00	8,944,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,529,325.20	72,124,103.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,974,000.00	68,024,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	4317143998 0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,400.00	157,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	3,358,151.18
210807	Газрын төлбөр	14,092.00	12,552.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,385,833.20	5,280.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,882,411.16	89,736,214.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,484,000.00	9,634,674.69
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,237,411.16	78,101,539.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,043,795.19	45,954,296.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,805,065.00	2,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,505,065.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	2,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,228,730.19	43,234,296.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,228,730.19	43,234,296.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,000.00	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	244,804,811.71	1,138,585.46
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	82,268,232.79	25,187,789.67
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	82,268,232.79	25,187,789.67
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	162,536,578.92	-24,049,204.21

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0	-14,976,909.71	354,884,516.13
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0	-14,976,909.71	354,884,516.13
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.84	0	-14,976,909.71	354,884,516.13
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
6	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
8	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
9	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
10	Тайлант үеийн үр дүн	0	0	-24,049,204.21	-24,049,204.21
11	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0	-39,026,113.92	330,835,311.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,025,069,200.00	1,040,236,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,000.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	45,000.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,000.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025,024,200.00	1,040,236,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,025,024,200.00	1,035,236,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,025,024,200.00	1,035,236,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	5,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,017,180,200.00	1,028,074,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,180,200.00	1,028,074,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,136,404.81	982,119,803.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,352,963.63	705,709,166.41
210101	Үндсэн цалин	479,473,370.76	439,797,722.05
210102	Нэмэгдэл	108,766,042.48	125,803,446.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,878,010.00	70,894,174.36
210104	Урамшуулал	52,235,540.39	69,213,823.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,910,949.18	93,066,633.03
210201	Тэтгэврийн даатгал	58,231,144.66	64,859,134.95
210202	Тэтгэмжийн даатгал	7,417,138.59	7,205,971.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,470,025.31	5,653,896.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,785.04	1,395,239.31
210205	Эрүүл мэндийн даатгал	13,447,855.58	13,952,390.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,358,000.00	44,376,301.00
210301	Гэрэл, цахилгаан	2,140,000.00	197,267.00
210302	Түлш, халаалт	0	6,766,086.00
210303	Цэвэр, бохир ус	0	112,948.00
210304	Байрны түрээс	51,218,000.00	37,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,974,200.00	35,419,500.00
210401	Бичиг хэрэг	3,579,900.00	6,571,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,133,000.00	6,172,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,055,000.00	8,612,440.00
210404	Ном, хэвлэл	447,600.00	231,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	684,700.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,074,000.00	13,738,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,748,000.00	9,882,590.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	3,088,000.00
210604	Урсгал засвар	1,748,000.00	6,794,590.00
2107	Томиллолт, зочны зардал	5,093,800.00	8,944,000.00
210702	Дотоод албан томиллолт	5,093,800.00	8,944,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,143,492.00	73,401,712.00

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,974,000.00	67,932,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,400.00	157,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	4,733,460.00
210807	Газрын төлбөр	14,092.00	12,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,555,000.00	11,319,901.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,484,000.00	9,319,901.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,043,795.19	45,954,296.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,805,065.00	2,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,505,065.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	2,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,228,730.19	43,234,296.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,228,730.19	43,234,296.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,000.00	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,889,000.00	12,162,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,889,000.00	12,162,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,889,000.00	12,162,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,889,000.00	12,162,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,889,000.00	12,162,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,889,000.00	-12,162,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,035,236,100.00	992,001,803.44	43,234,296.56	95.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,035,236,100.00	992,001,803.44	43,234,296.56	95.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,032,516,100.00	989,281,803.44	43,234,296.56	95.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,311,000.00	705,709,166.41	34,601,833.59	95.33
210101	Үндсэн цалин	452,015,400.00	439,797,722.05	12,217,677.95	97.30
210102	Нэмэгдэл	131,997,900.00	125,803,446.57	6,194,453.43	95.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,860,000.00	70,894,174.36	3,965,825.64	94.70
210104	Урамшуулал	81,437,700.00	69,213,823.43	12,223,876.57	84.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,448,000.00	93,066,633.03	7,381,366.97	92.65
210201	Тэтгэврийн даатгал	70,835,500.00	64,859,134.95	5,976,365.05	91.56
210202	Тэтгэмжийн даатгал	7,403,100.00	7,205,971.35	197,128.65	97.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,922,500.00	5,653,896.86	268,603.14	95.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,480,700.00	1,395,239.31	85,460.69	94.23
210205	Эрүүл мэндийн даатгал	14,806,200.00	13,952,390.56	853,809.44	94.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,625,600.00	44,376,301.00	1,249,299.00	97.26
210301	Гэрэл, цахилгаан	818,600.00	197,267.00	621,333.00	24.10
210302	Түлш, халаалт	7,000,000.00	6,766,086.00	233,914.00	96.66
210303	Цэвэр, бохир ус	507,000.00	112,948.00	394,052.00	22.28
210304	Байрны түрээс	37,300,000.00	37,300,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,421,000.00	35,419,500.00	1,500.00	100.00
210401	Бичиг хэрэг	6,560,000.00	6,571,300.00	-11,300.00	100.17
210402	Тээвэр, шатахуун	6,172,000.00	6,172,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,890,000.00	8,612,440.00	277,560.00	96.88
210404	Ном, хэвлэл	261,200.00	231,200.00	30,000.00	88.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,400.00	93,600.00	67,800.00	57.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,376,400.00	13,738,960.00	-362,560.00	102.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,794,700.00	11,794,590.00	110.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	6,794,700.00	6,794,590.00	110.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	8,944,000.00	8,944,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	8,944,000.00	8,944,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,651,800.00	73,651,712.00	88.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,932,300.00	67,932,300.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,400.00	157,400.00	0.00	100.00

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,983,500.00	4,983,460.00	40.00	100.00
210807	Газрын төлбөр	12,600.00	12,552.00	48.00	99.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,320,000.00	16,319,901.00	99.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,320,000.00	9,319,901.00	99.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,720,000.00	2,720,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,720,000.00	2,720,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,720,000.00	2,720,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,035,236,100.00	992,001,803.44	43,234,296.56	95.82
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,035,236,100.00	992,001,803.44	43,234,296.56	95.82
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,035,236,100.00	992,001,803.44	43,234,296.56	95.82

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	5,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,000,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	5,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс /цаашид Татварын хэлтэс гэх/ -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 61 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Татварын хэлтэс нь тайлант онд “Татварын хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдөлтийг олон улсын түвшинд хүргэх, хууль тогтоомж даган мөрдөлтийн эрсдэлийг удирдах, татварын албаны дотоод чадавхыг бэхжүүлж, үр ашгийг сайжруулах” зорилго тавин ажилласан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
- Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,067,202.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,672.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 8,004.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Татварын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,073.0 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	976.20	976.20
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	28,908.00	31,312.80	2,404.80
Үндсэн хөрөнгө	325,976.50	299,522.50	(26,454.00)
Нийт хөрөнгө	354,884.50	331,811.50	(23,073.00)
Өр төлбөр	-	976.20	976.20
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	354,884.50	330,835.30	(24,049.20)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	354,884.50	331,811.50	(23,073.00)

Бараа материалын дансны үлдэгдэл 31,312.8 мянган төгрөг болж 2,404.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42,471.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 18,982.2 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан, 59,048.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 572,139.5 мянган төгрөг болж 53,945.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12,162.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан болон 41,783.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 330,835.3 мянган төгрөг болж 24,049.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,211.9 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 10,211.9 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 27,362.3 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс болон НДШ-ийн зардал 29,511.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 9,594.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 33,853.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 68,505.1 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

4317143998
МН А0065 9056436

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,218,880.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 183,643.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,035,236.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Цалин, хөлс болон НДШ-ийн зардлыг 76,467.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 30,818.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 10,026.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 78,622.1 мянган төгрөгөөр бууруулан баталсантай байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,035,236.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,035,236.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 992,001.8 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 41,983.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,249.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, тайлант хугацааны эцэст төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс татвар төлөгчдийн өдрүүдэд 2,000.0 мянган төгрөг, татварын албадыг Гэрэгэ пос машинаар хангах ажлын хүрээнд 3,000.0 мянган төгрөгийн зэрэг нийт 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, багаж техник хэрэгсэл худалдан авахад 3,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. ТЕГ-ын даргын 2021 оны А/102 дугаар тушаалаар нягтлан бодогч Ш.Энхбаяр, нярав Б.Мөнхзаяа нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх буюу 1,416.2 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан буюу тогтоосон хэмжээг хэтрүүлэн олгох шийдвэр гаргасан байна.

Иймд тухайн албан тушаалтнууд холбогдох хууль эрхийн актын дагуу улирал бүр ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал авч байхад санхүүгийн тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан, санхүүгийн үйл ажиллагаа сайн гэх үндэслэлээр буюу улирлын ажлын үр дүнгийн зөвхөн 1 үзүүлэлтийг үндэслэн урамшууллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн, давхардуулан олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс гаргахгүй байх нь зүйтэй юм.

2. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг “0” болсон 144,808.1 мянган төгрөгийн 47 нэр төрлийн хөрөнгийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3. Татварын ерөнхий хуулийн 6.1.39-д “Хураагч гэж татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалт хийх, хяналт шалгалт хийхээс бусад чиг үүргийг хэрэгжүүлж байгаа татварын албаны ажилтныг хэлнэ”, 74.2-т “Монголын татварын алба нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг, тосгоны татварын газар, хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, **хураагчаас** бүрдэнэ”, Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах **албан тушаалын жагсаалтыг** төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл татвар хураагчийн ангилал, зэрэглэлийг Засгийн газар бус байгууллагын дотоод журмаар “Хураагчийг төрийн үйлчилгээний албан тушаалын ТҮ-6 дугаар ангилал зэрэглэлд хамааруулж, цалин хөлс олгоно.” гэж зохицуулж, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, батлаагүй байна.

Иймд татвар хураагчийн албан тушаалын тодорхойлолтыг хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулах, Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүргийг байгууллагын дотоод журмаар зохицуулахгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

4. Сангийн сайдын 2020 оны 168 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам”-ын 1.2-т “Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагналыг **сар бүр** олгож болох бөгөөд тухайн албан хаагчийн сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасан нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид **улирлын** ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Татварын хэлтсийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож, 145 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.


3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Татварын хэлтсийн тайлант оны үйл ажиллагаанд 1,035,236.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 992,001.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.2 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	1	-	1	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 36,537.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 33,554,0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтын и-баримт бөөн дүнгээр цахим системд шивэгдсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, **бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана.** гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг бараа, үйлчилгээний нэр төрөл тус бүрээр гаргуулж, бүртгэх.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс төлөвлөгөөт сургалтын зардал 2,983.4 мянган төгрөгийг мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас санхүүжүүлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс	2	36,537.4	-	-	-	-	-	-	2	36,537.4